# НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 10 өдөр Дугаар А/55 Улаанбаатар хот

Ажлын хэсгийг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/372 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал, заавар"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжийн 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, хийж хэрэгжүүлсэн ажлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг 2019 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шалгах ажлын удирдамжийг хоёрдугаар, шалгалтын хуваарийг гуравдугаар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд шаардагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Шалгалтад бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг бүтцийн нэгжийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

4. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардагдах 294.920 (хоёр зуун ерэн дөрвөн мянга есөн зуун хорин) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

5. Шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу явуулж, дүнг 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, хурандаа Д.Мөнхсайханд үүрэг болгосугай.

ДАРГА,
ХУРАНДАА Ж.ЧУЛТЭМСҮРЭН

1117155601
УХА0038 9077073

D/:My documents-blank-2019-tushaal

00115050 489

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
А/55 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

| | |
|---|---|
| Д.Мөнхсайхан | Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа |

Гишүүдэд:

| | |
|---|---|
| Ж.Төмөрмандах | Дотоод, хяналт шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч, |
| Д.Оюунбат | Нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа, |
| Б.Чинбат | Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа, |
| Ж.Алтанхуяг | Гал түймэр унтраах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа, |
| С.Содонтуяа | Хүний нөөц, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа, |
| А.Чинбат | Хангалт үйлчилгээ, орон сууц, байрны ашиглалт хариуцсан мэргэжилтэн, дэд хурандаа |
| Р.Мөнхбат | Дотоод ажил, төлөвлөлт хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч |
| Э.Энх-Амгалан | Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад, |
| Д.Шижирболд | Дайчилгаа, Улсын албад нүүлгэн шилжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад |
| Б.Мягмаржав | Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, ахмад, |
| О.Мөнхбат | Хөдөлмөр хамгаалал, хорт хий утаанаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад, |
| С.Буяннэмэх | Ахлах нягтлан бодогч, ахмад |
| Ч.Батболд | Дотоод, хяналт, шинжилгээ, үнэлгээ, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад |
| Б.Сэрдамба | Техник, тоног төхөөрөмж хариуцсан инженер, ахмад, |
| Э.Эрдэнэбаатар | Нягтлан бодогч, дэслэгч, |
| Э.Пүрэв-Очир | Хуулийн зөвлөх, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн, дэслэгч |
| Ө.Мөнх-Отгон | Төлөвлөлт хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, дэслэгч, |

| | |
|---|---|
| Нарийн бичиг: | |
| Ц.Чинзориг | Эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад |
| Жолооч: | |
| Н.Ганбаяр | Нийслэлийн Аврах анги-105-ын шуурхай албаны жолооч, ахлах ахлагч, |

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
А/55 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117155601
УХА0038 9077073

# ШАЛГАЛТ ЯВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

## Нэг. Зорилго:

1.1. Төрийн бодлого шийдвэр, хууль, тогтоомж, байгууллагын хэтийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтыг хангах чиглэлээр Нийслэлийн Онцгой байдлын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажил үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг үнэлэх Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 107 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам", Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/372 дугаар тушаалаар батлагдсан "Аргачлал, заавар батлах тухай"-ыг хэрэгжүүлэхэд оршино.

## Хоёр. Шалгалтын зохион байгуулалт:

2.1. Шалгалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/372 дугаар тушаалаар батлагдсан "Аргачлал, заавар батлах тухай"-ыг баримтлан зохион байгуулна.

2.2. Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, тогтоомжийн хүрээнд хууль дээдлэх, хараат бус, бие даасан, шударга, бодитой нууц хадгалах зарчимд тулгуурлан явагдана.

## Гурав. Хамрах хүрээ, хугацаа:

3.1. Бүтцийн нэгжийн 2019 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, алба хаагчдын сахилга, хариуцлага, дэг журмыг бэхжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах.

3.2. Шалгалтад хамрагдсан нэгжийн бүтэц, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийх,

3.3. Шалгалтыг 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрүүдэд зохион байгуулна.

## Дөрөв. Шалгалт явуулах ажлын чиглэл

1. Удирдлага зохион байгуулалт, сахилга, ёс зүй, дотоод үйл ажиллагаа
- Удирдлага зохион байгуулалт, дотоод үйл ажиллагаа
- Бие бүрэлдэхүүний сургалт
2. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа
3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа
- Гамшгийн хор уршгийг арилгах чиглэлээр.
- Гамшгаас хамгаалах улсын хяналтын чиглэлээр
- Гал түймрийн улсын хяналтын чиглэлээр
- Техникийн бэлтгэл бэлэн байдлын чиглэлээр
- Холбоо зарлан мэдээллийн чиглэлээр
4. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр шалгалтыг явуулна.

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн
А/55 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

## ШАЛГАХ АЖЛЫН ХУВААРЬ

| № | Салбар, нэгжийн нэр | Шалгалт явуулах өдөр/цаг | Шалгалт явуулах газар |
|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/12<br>14:00 | НОБГ<br>Соёлын төв |
| | Гал түймэр унтраах, аврах 11 дүгээр анги | | |
| | Гал түймэр унтраах, аврах 26 дугаар анги | | |
| | Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр анги | | |
| 2 | Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/12<br>16:00 | |
| | Гал түймэр унтраах, аврах 34 дүгээр анги | | |
| | Гал түймэр унтраах, аврах 74 дүгээр анги | | |
| 3 | Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/12<br>18:00 | |
| | Гал түймэр унтраах, аврах 18 дугаар анги | | |
| 4 | Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/12<br>19:00 | |
| | Гал түймэр унтраах, аврах 10 дугаар анги | | |
| 5 | Нийслэлийн Аврах анги-105 | VI/12<br>20:00 | |
| 6 | Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв | VI/12<br>21:00 | |
| 7 | Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/13<br>14:00 | НОБГ<br>Соёлын төв |
| | Гал түймэр унтраах, аврах 64 дүгээр анги | | |
| 8 | Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/13<br>16:00 | |
| | Гал түймэр унтраах, аврах 80 дугаар анги | | |
| 9 | Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/13<br>18:00 | |
| | Гал түймэр унтраах, аврах 28 дугаар анги | | |
| 10 | Хан-уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/13<br>19:00 | |
| | Гал түймэр унтраах, аврах 14 дүгээр анги | | |
| | Гал түймэр унтраах, аврах 30 дугаар анги | | |
| | Гал түймэр унтраах, аврах 65 дугаар анги | | |
| 11 | Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс | VI/13<br>20:00 | |
| | Гал түймэр унтраах, аврах 35 дугаар анги | | |
| | Гал түймэр унтраах, аврах 63 дугаар анги | | |
| 2019 оны эхний хагас жилийн ажлын үнэлэлт, дүгнэлтийг даргын зөвлөлийн хуралд танилцуулж хэлэлцүүлэх | | VI/14 | Хошууч Ж.Төмөрманд ах |

---o0o---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 06 дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

## ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХООЛНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

| д/д | Зардлын нэр | Нэгжийн үнэ /төгрөг/ | Хамрагдах алба хаагчдын тоо | Шалгалт хийх өдөр | Өдөрт хооллох тоо | Нийт үнэ /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хоол | 5000 | 13 | 2 | 2 | 260000₮ |
| Дүн | | | | | | 260000₮ |

## АВТОМАШИНЫ ШАТАХУУНЫ ТООЦОО

| Анги, салбар | Автомашин | | Явах зай, км | Шатахуун | | | Үнэ, төгрөг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын дугаар | марк | | Төрөл | 100 км-т зарцуулах | нийт, л | Нэгж үнэ | Нийт үнэ |
| НОБГ | 87-62 УНТ | Старекс | 100 | АИ-92 | 18 | 18л | 1940 | 34920₮ |
| Дүн | | | | | | | | 34920₮ |

## НИЙТ ДҮН

| № | Зардлын төрөл | Дүн /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Хоол | 260,000 |
| 2 | ШАТАХУУН | 34,920 |
| НИЙТ | | 294,920 |

---o0o---